

“ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС” ХК

2022 оны 05 дугаар сарын 14-ний өдөр

№ ХЭХ 02/2022

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ШИЙДВЭР

Компани нэмж энгийн
хувьцаа гаргах тухай

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 31 дүгээр зүйлийн 31.2.2, 38 дугаар зүйлийн 38.8, 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.3, 62.1.15, 63 дугаар зүйл, 69 дүгээр зүйл, “Эрдэнэс сольюшинс” ХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6.1, 8.6.4 дэх заалтууд, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 04 дүгээр сарын 03-ний өдрийн ТУЗТ 07/2022 тоот тогтоол, Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ШИЙДВЭРЛЭХ** нь:

1. Компани зарласан хувьцаанаас 16,572,469 (арван зургаан сая таван зуун далан хоёр мянга дөрвөн зуун жаран ес) ширхэг хүртэлх энгийн хувьцааг нэмж гарган “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-аар дамжуулан нийтэд санал болгох замаар худалдсугай.
2. Нийтэд санал болгон нэмж гаргаж буй энгийн хувьцааны анхдагч зах зээлийн арилжааны захиалгын хэмжээ нэмж гаргаж буй 16,572,469 (арван зургаан сая таван зуун далан хоёр мянга дөрвөн зуун жаран ес) ширхэг энгийн хувьцааны захиалгаас давсан нөхцөлд дахин 1,949,129 (нэг сая есөн зуун дөчин есөн мянга нэг зуун хорин ес) ширхэг хүртэлх энгийн хувьцааг нэмж эргэлтэд гаргасугай.
3. Компанийн нэмж гаргаж буй энгийн хувьцааг одоо компанийн хувьцааг эзэмшиж буй эзэмшигчдэд тэргүүн ээлжид худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байхаар шийдвэрлэсүгэй.
4. Компанийн нэмж гаргаж буй энгийн хувьцааны зах зээлийн үнэ тогтоох эрхийг Төлөөлөн удирдах зөвлөлд олгосугай.
5. Компани нэмж энгийн хувьцаа нийтэд гаргахтай холбоотойгоор Компанийн дүрмийн шинэчилсэн төсөлийг 1-р хавсралтаар баталсугай.
6. Компанийн 2022 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн ээлжит бус хурлын 12.00 цагт Google Meet joining info Video call link: <https://meet.google.com/rkb-xhah-ept> байхаар зарлан хуралдуулсан видео бичлэгийг хадгалсугай.

ХУРЛЫН ДАРГА



/Г. ЗОЛБОО/